

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



20 25 оны 06 сарын 27 өдөр

№ R-2025-28

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг
эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хороо ("СЗХ")-ны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ХасБанк ХК ("Банк")-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл ("ТУЗ")-ийн 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн ээлжит бус хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. ТУЗ 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн R-2025-27 дугаар тогтоолоор Банкны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулахаар шийдвэрлэснийг; мөн
2. Банкны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг эцэслэн батлах зорилгоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалт хэлбэрээр, цахимаар зохион байгуулах нь зүйтэй гэж ТУЗ үзсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал ("ХЭЭБХ")-ыг 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн хооронд эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулж хуралдуулсугай.
2. ХЭЭБХ Зохион байгуулах комиссын даргаар Банкны Ерөнхий аудитор Э.Ундармааг томилсугай. Тус комиссын гишүүдийг холбогдох дотоод журмын дагуу томилохыг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд үүрэг болгосугай.
3. ХЭЭБХ-ын мэдэгдлийг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор СЗХ болон Монголын Хөрөнгийн Бирж ("МХБ")-д хүргүүлэхийг ТУЗ-ийн Ажлын албанд даалгасугай.
4. ХЭЭБХ зохион байгуулах тухай зар мэдээг МХБ-ийн цахим хуудас, өдөр тутмын сонин, Банкны албан ёсны веб сайт (www.xacbank.mn), сошиал орчин дахь албан ёсны хаягаар болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, зарын давталтыг тийнхүү нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх зарласан хэлбэрээр дахин нэг удаа нийтэд мэдээлэхийг Зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
5. Эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулж буй ХЭЭБХ-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдөр байхаар тогтоосугай.

6. ХЭЭБХ-аар шийдвэрлэх асуудлын жагсаалт, гаргах шийдвэрийн төсөл, саналын хуудас болон бусад холбоотой баримт бичгийг 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлэхийг Зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
7. ХЭЭБХ-аар шийдвэрлэх асуудлыг 1 дүгээр хавсралтаар, ХЭЭБХ-аар шийдвэрлэх асуудалтай холбоотой баримт бичгийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар, Тооллогын комиссын бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралтаар, саналын хуудсыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчид шийдвэрлэх асуудалтай холбоотой баримт бичигтэй ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулагдсан ХасМийтинг аппликейшнээр дамжуулан танилцах боломжийг хангаж ажиллахыг Зохион байгуулах комисст даалгасугай.
9. Эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулж буй ХЭЭБХ-аас гарсан шийдвэр, бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд МХБ, СЗХ-д хүргүүлэхийг ТУЗ-ийн Ажлын албанд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ